



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар A156

Сангийндалай

12 айлын орон сууц буулгах, газар чөлөөлөх зардал гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 12 айлын орон сууц буулгах, газар чөлөөлөх ажлыг “Өв хангамж групп ХХК”-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.
2. Уг ажилтай холбогдон гарах зардал 20,000,000 (хорин сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.
3. Уг ажилд холбоотой гарсан зардалд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА

